

1. Япон улсын ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн сургалтад оролцогч Мөнхтуулын тайлан №4 Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүн хөдөлмөр эрхлэх боломжтой

ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмждэг Япон улсын томоохон корпораци болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч бизнесийн байгууллагуудаар зочилсон бяцхан тэмдэглэлийг цувралаар танилцуулж байгаа билээ. Өмнөх мэдээллээр бид та бүхэнд оюуны бэрхшээлтэй хүмүүсийг ажиллуулдаг усан үзэм тариалж, дарс үйлдвэрлэдэг компанийн үйл ажиллагааны тухай товч танилцуулсан. Энэ удаад сэтгэц, оюуны бэрхшээлтэй хүмүүсийг ажиллуулдаг жижиг дунд үйлдвэрийн тухай танилцуулахаар бэлтгэлээ.

Зэвэрдэггүй ган, хөнгөн цагаан, төмөр, гууль, зэс, никель, резин зэрэг олон төрлийн материалаар, ф1-ээс ф42 хүртэлх өндөр нарийвчлалтай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг Шинкоша компанийг танилцуулж байна. Тэд 20 жилийн өмнөөс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажиллуулж эхэлсэн бөгөөд одоо 12 ажилтантай ба зургаан хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллаж байна.

Хэдийгээр тэд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулдаг ч хэрэглэгчийн захиалгын хугацааг хойшлуулахгүй, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэнэ гэсэн зарчимтай ажилладаг.



Шинкоша компанийн оюуны бэрхшээлтэй ажилтан.

Тус компанийн үйлдвэрийн газрын дарга хэлэхдээ “Би хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ажил олгох үйл ажиллагаагаа үргэлжлүүлсээр байх болно. Учир нь хүн бүрд өөрийн гэсэн ‘хүч’ оршдог. Харин менежер хүн тэр ‘хүч’-ийг нээн илрүүлж, яг тохирсон ажлыг хийлгэх нь чухал” хэмээн хэлж байлаа.

Шинкоша компанийн үйл ажиллагаатай танилцаж байхад хүн бүр хийх ёстой ажлаа хийдэг мөн хамт олны харилцаа ч халуун дулаан байдаг нь мэдрэгдэж байсан юм. Хөгжлийн бэрхшээлтэй эсвэл хөгжлийн бэрхшээлгүй байхаас үл хамааран ажилтныг тохирсон ажилд томилох явдал чухал ажээ. Япон улсын ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтэд бусад улс оронтой адил саад бэрхшээлтэй олон зүйл тулгардаг хэдий ч гол нь тууштай байдал нь одоогийн түвшинд хүргэжээ.



Дурсгалын зураг.

2. Монголын хоёр оролцогч гэрчилгээгээ гардан авлаа

Японы ЖАЙКА-Чүбү төвөөс зохион байгуулсан ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтад Монголоос хоёр оролцогч оролцсон.

Хөтөлбөрт оролцогч 6 орны төлөөллүүд ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн сайн жишээ Тоёота Моторс Корпораци болон ЖДҮ эрхлэгч дарсны үйлдвэрлэл, төмөр болон резинэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч Шинкоша, төрийн байгууллагын үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэдэг Сонэ Озонэ, Эй Жэй Юү бие даан амьдрах төвийн Вадачи Компьютер Хаус зэрэг хөгжлийн бэрхшээлтэй тэр дундаа хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ажил олгож байгаа байгууллагуудын бодит үйл ажиллагаатай танилцсан.



Төлөвлөгөөгөө танилцуулах үеэр.

СЭДЭВ

1 ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн сургалтад оролцогч Мөнхтуулын тайлан №4 Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүн хөдөлмөр эрхлэх боломжтой

2 Монголын хоёр оролцогч гэрчилгээгээ гардан авлаа

3 Ажлын байрны дадлагажуулагчийн чадавхийг бэхжүүлэх сургалтыг зохион байгууллаа



Зургаан орны оролцогчид.

Бүх оролцогчид төлөвлөгөөгөө танилцуулсны дараа хөтөлбөрийг амжилттай дүүргэсэн гэрчилгээгээ ЖАЙКА-Чүбү төвийн даргаас гардан авсанаар хөтөлбөр амжилттай өндөрлөв.

ЖАЙКА-Чүбү төв нь КССР хөтөлбөрийг ирэх жил дахин зохион байгуулах бөгөөд Монголоос оролцогчдыг хүлээж байгаагаа дамжуулж байна.

Хөтөлбөрт оролцсон зургаан орны төлөөлүүдийн гурав нь төрийн байгууллагын ажилтнууд байсан бөгөөд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хөдөлмөр эрхлэх боломж бүрдүүлэхэд төрийн байгууллагуудын шийдвэр гаргах түвшний хүмүүсийн оролцоо, дэмжлэг ямар чухал болохыг онцлолж байлаа. Мөн тухайн орон нутгийн иргэд болоод ХБИ-ийн байгууллагууд төрийн байгууллагатайгаа нягт хамтран ажиллах нь эерэг үр дүнд хүргэдэг гэдгийг маш сайн ойлголоо хэмээн сэтгэгдэлээ илэрхийлж байсан.

Хөтөлбөрийн төгсгөлд бүх оролцогчид хөтөлбөрөөс суралцсан зүйлсээ өөрсдийн улс оронд очоод хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хөтөлбөрийг зохион байгуулагч болон бусад оролцогчидоо танилцуулав.



Дурсгалын зураг.

3. Ажлын байрны дадлагажуулагчийн чадавхийг бэхжүүлэх сургалтыг зохион байгууллаа



ХБХХЕГ-аас журамд орсон өөрчлөлтийг танилцуулж байна.

DPUB2 төслийн хүрээнд ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны шинэчилсэн журам болон санхүүжилтийн талаар танилцуулах, чадавхийг бэхжүүлэх сургалтыг 2023 оны 3-р сарын 7-ны өдөр ажлын байрны дадлагажуулагч нарт зохион байгууллаа.

Сургалтыг нээж ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Тунгалагтамир нээж үг хэллээ. Ажлын байрны дадлагажуулагчийн үйлчилгээг төрийн зүгээс бодлого болон санхүүжилтээр дэмжин ажиллаж байна. Тиймээс ТББ, хөдөлмөрийн бирж, Ажлын байрны дадлагажуулагч нар зэрэг олон талуудын бодит үйл ажиллагаанаас ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлт ихээхэн хамаарна гэдгийг онцлон захив.

Харин төслийн ахлах зөвлөх Чива Хисао Монгол улсад дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг шинэ журамтай уялдуулан хэрэгжүүлж байгаа ажлын байрны дадлагажуулагчдад талархаж байгаагаа илэрхийлэв.

ХБХХЕГ-ын Бодлогын хэрэгжилтийн газрын дарга У.Сосорбурам мөн тус газрын ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ хариуцсан мэргэжилтэн Б.Сүхтогоо нар “Ажлын байрны дадлагажуулагчийн үйл ажиллагааг зохицуулах журам”-д орсон шинэ өөрчлөлтийг танилцууллаа. ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтэд цогц дэмжлэг үзүүлэх үйлчилгээг хэрэгжүүлж байгаа ТББ-ууд, Хөдөлмөрийн биржийн төлөөлүүдийн зүгээс олон асуулт тавьж, шинэчилсэн журам илүү боловсронгуй болсон байгаад талархаж байлаа.

✉ dpub.jica@gmail.com

📍 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол Улс, Улаанбаатар-15160, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж-5

🌐 <https://www.facebook.com/jicadpub1and2>

🌐 <https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/030/index.html>

